

ТАНИЛЦУУЛГА

*Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх зорилтыг дэвшүүлэн “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”, “Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тулгуур зарчмуудыг баримтална” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих, орон нутагт бизнесийн орчныг дэмжих, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, гарааны бизнесийг дэмжиж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхээр заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон нутагт бизнес эрхлэлтийг дэмжих шаардлага тулгарч буйг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдал бэхжих боломжтой. Мөн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулснаар гадаадын хөрөнгө оруулагч нарт илүү таатай орчин бүрдэж, татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх зорилтыг дэвшүүлэн “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”, “Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тулгуур зарчмуудыг баримтална” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих, орон нутагт бизнесийн орчныг дэмжих, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, гарааны бизнесийг дэмжиж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхээр заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон нутагт бизнес эрхлэлтийг дэмжих шаардлага тулгарч буйг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь жижиг, дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх үндсэн зорилготой байсан.

Гэвч хуулийн шинэчлэлээс хойших зургаан жилийн хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх, зээлийн хүү нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулалт буурах зэрэг нийтлэг санхүүгийн хүндрэл, эрсдэлүүд дэлхийн нийгэм, эдийн засгийн төлөвт бий болсон.

Монгол Улсын хувьд инфляцын түвшин жил бүр өсөн нэмэгдэж, 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар 9 хувьд хүрсэн ба эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлаас үүдэн бизнесийн орчны бүтэц, хөрөнгө оруулалтын чиг хандлага эрчимтэй өөрчлөгдөж байна.

Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд татварын бодлогоор жижиг, дунд бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал Япон, Энэтхэг, Канад зэрэг улс орнууд бизнес эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний татварын ачааллыг бууруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Мөн Сингапур, Англи, Казакстан зэрэг улсууд хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг сайжруулах, татварын орчныг энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн байна. Эдгээр өөрчлөлт нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хувьд жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар буурах, мөнгөн хөрөнгийн дутагдалд орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалах болон хөрөнгө оруулалт шинээр татахад хүндрэл үүсэж байна. Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт аж ахуйн нэгжүүдийн 57 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай байгаа нь 2019 оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, нийт аж ахуйн нэгжүүдийн 34 хувь буюу 32 мянга гаруй компани алдагдалтай ажилласан байна. Иймээс дээрх үүсээд буй нөхцөл байдлуудыг шийдвэрлэхийн тулд татварын бодлогын зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газраас хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан бөгөөд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлоготой уялдуулан бүсийн хөгжлийн бодлогод нийцсэн татварын бодлого хэрэгжүүлэх шаардлага үүссэн. Энэ хүрээнд бүс, орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бие даасан бодлого хэрэгжүүлэх нөхцөлийг хуулийн хүрээнд бүрдүүлэх шаардлага бий болоод байна.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 150 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд татвар ногдуулах орлогын босго, шатлалыг өөрчлөх, бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтыг тусгана. Үүнд:

1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тэдний татварын ачааллыг бууруулах, татварын орчныг сайжруулах, бизнесүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах, хуримтлал үүсгэх, бизнесийн өргөжих боломжийг нэмэгдүүлнэ.

Дээр дурдсан асуудлуудыг тусгасан зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд тус тус тусгалаа.

2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан тэргүүлэх чиглэлийн хүрээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувийг бүс, орон нутаг өөрийн онцлог, эдийн засгийн бодлогодоо нийцүүлэн дээд хязгаарт багтаан бие даан тогтоох эрхийг олгоно.

Дээрх зохицуулалтыг хуулийн төслийн 3 дүгээр зүйл болон 6 дугаар зүйлд тус тус тусгалаа.

3. Гадаадын хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөжийг өсгөж, гадаадын хөрөнгө оруулалтын илүү таатай орчин бүрдүүлнэ. Үүний үр дүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах эерэг үр дүн гарах юм.

Дээрх зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдал бэхжих боломжтой. Мөн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулснаар гадаадын хөрөнгө оруулагч нарт илүү таатай орчин бүрдэж, татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

---oOo---

INTRODUCTION

On Draft Law to Amend the Entity Income Tax Law

The long-term development policy of Mongolia "Vision 2050", approved by Resolution No. 52 of the State Great Khural of Mongolia, includes objectives to enhance the competitiveness of small and medium enterprises (SMEs), create a favorable investment environment and conditions to promote micro, small, and medium businesses. The mid-term development program "New Recovery Policy," approved by Resolution No. 106 of the State Great Khural of Mongolia on December 30, 2021, includes measures to support citizens and businesses relocating from Ulaanbaatar to rural areas through comprehensive policy, improve the business environment, support small and medium industries, services, and startups, and increase employment in rural areas.

Mongolian Government Action Plan for 2024-2028, approved by State Great Khural Resolution No. 21 in 2024, outlines tax and social insurance reforms in Section 3.2.1 of its first annex. These reforms aim to reduce the tax burden on businesses, optimize tax incentives to improve the tax environment, create a regionally differentiated tax system, and support compliant taxpayers.

To achieve these objectives, foster a more favorable business environment, attract increased investment, and specifically support rural business activities, a draft law amending the Law on Entity Income Tax will be developed.

The 2019 tax reform package, encompassing the General Tax Law, the Corporate Income Tax Law, and the Individual Income Tax Law, was approved by the State Great Khural and took effect in 2020. This reform aimed to support small and medium-sized enterprises, modernize tax processes through digitalization, and incorporate contemporary international taxation principles into domestic law.

However, in the six years following the legal reforms, persistent geopolitical instability, coupled with trade policy uncertainty, contributed to a slowdown in major economies, rising inflation, increased interest rates, and declining foreign investment, creating widespread financial challenges and risks in the global economic landscape.

In Mongolia, inflation has risen steadily each year, reaching 9% by the fourth quarter of 2024. This economic and financial situation is driving significant changes in the structure of the business environment and investment trends.

Within this context, countries around the world have used tax policies to promote the growth and development of SMEs in the recent years. For example, Japan, India, and Canada have implemented tax incentives for SMEs to reduce financial burdens, increase employment, and stimulate economic growth. Additionally, countries such as Singapore, the UK, and Kazakhstan have made changes aimed to attract investment, enhance the business environment, and simplify and clarify their tax systems. These changes play a crucial role in ensuring the financial stability of SMEs, enhancing their competitiveness, and supporting economic growth.

Mongolian SMEs face significant challenges, including declining payment capacity, cash shortages, and difficulty securing new investments, threatening their stability. As of 2023,

approximately 57% of all businesses in Mongolia are experiencing cash shortages, which is a 27% increase compared to 2019. In addition, 34% of all businesses, or over 32 thousand companies, have operated at a loss. Therefore, it has become necessary to implement appropriate tax policy measures to address these emerging challenges.

Moreover, the Government of Mongolia government declared 2024 as the "Year of Regional Development Support" in order to achieve a balance in the development of urban and rural areas. To support this concept and Mongolian Government Action Plan for 2024-2028, tax policies must be further aligned with regional development goals. In light of these circumstances, it is imperative to establish the legal framework necessary to enhance regional and local autonomy to attract investment, and implement independent economic policies.

The Ministry of Finance, tax and customs authorities, the Mongolian National Chamber of Commerce and Industry, and the Secretariat of the State Great Khural jointly organized 150 meetings and discussions across the country, involving more than 11,000 taxpayers, and received around 150,000 proposals. The discussions produced proposals for changes to income thresholds and tax brackets, as well as to address common issues faced by business owners.

The draft law shall be formulated based on the following key principles and shall encompass the following regulatory provisions:

1. To support small and medium enterprises (SMEs), reduce their tax burden, improve the tax environment, promote sustainable operations, facilitate reserve accumulation, increase opportunities for business expansion, and address common issues faced by enterprises.

The regulations addressing the aforementioned issues are included in Articles 1, 2, 3, 4, 5, and 6 of the draft law.

2. In accordance with the priorities set forth in the regional development concept, the draft law will allow the regions and local authorities to independently determine tax rates within a defined limit, based on their unique characteristics and economic policies.

The regulations addressing the aforementioned issues are included in Articles 3 and 6 of the draft law.

3. To increase the returns for foreign investors and create a more favorable environment for foreign investment. As a result, this will lead to attracting foreign direct investment, stimulating reinvestment, increasing capital flows, and ensuring positive outcomes for stable economic growth.

The regulations addressing the aforementioned issues are included in Article 1.

Therefore, in response to the above challenges, a draft law amending and supplementing the Law on Entity Income Tax has been developed.

If approved, this draft law will boost Mongolia's business competitiveness globally and ease the tax burden on business owners. As a result, economic growth is expected to

increase, and social stability can be strengthened. Additionally, improving the investment environment will create a more favorable atmosphere for foreign investors, expand the tax base, and increase budget revenue.

---oOo--